



 ГОЛОМТ БАНК

ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН
ТАЙЛАН | 20
21

Голомт банкны Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд баримталж буй стратеги



Тогтвортой
бизнесийн үйл
ажиллагаа явуулах



Нийгэм, байгаль
орчны асуудлуудад
анхаарал тавих



Сэтгэл ханамжтай
ажлын байр
бий болгох

Голомт банкны “Тогтвортой хөгжлийн бодлого”-ын хүрээнд 2021 онд хийж хэрэгжүүлсэн ажлаа энэхүү тайлангаар дамжуулан танилцуулж байна.

Та бүхэнд Голомт банкны “Тогтвортой хөгжлийн бодлого” болон “Тогтвортой хөгжлийн тайлан”-тай холбоотой санал, хүсэлт байвал sustainablefinance@golomtbank.com хаягаар бидэнтэй холбогдоорой.

Агуулга

БИДНИЙ ТУХАЙ

8-14

- Голомт банк
- Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
- ТоС-ын хүрээнд Голомт банкны нэгдсэн олон улсын санаачилга, хамтын амлалт
- Тогтвортой хөгжлийн он цагийн товчоо

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ 2022-2025

15-17

- Тогтвортой засаглал
- Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ
- Тогтвортой санхүүжилт
- Хамтын ажиллагаа, амлалтууд

18-31

1. Засаглал

- Байгууллагын Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны бүтэц
- Жендерийн хороо
- Тогтвортой хөгжлийн хороо
- Тогтвортой санхүүжилтийн хэлтэс
- Компаенсийн бодлого
- Мэдээллийн аюулгүй байдлын бодлого

2. Зээлийн БОН-ийн эрсдэлийн менежмент

- БОН-ийн эрсдэлийн үнэлгээний бодлого
- 2021 онд нийт үнэлсэн зээлийн хувь, эрсдэлийн зэргийн ангилал

3. Тогтвортой санхүүжилт

- Хөрөнгө оруулалт, эх үүсвэр
- Гадаад хамтын ажиллагаа
- Ногоон санхүүжилт
- Жендерийн санхүүжилт
- ЖДҮ санхүүжилт
- Төсөл хөтөлбөрийн санхүүжилт
- Дижитал банк

4. Тогтвортой үйл ажиллагаа, хүний нөөцийн удирдлага

- Ковид-19 цар тахлын үед банкны авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
- Сэтгэл ханамжтай, тогтвортой ажлын байр
- Ажилтнуудад зориулсан сургалт, тэтгэмж, хөнгөлөлт
- Байгаль орчинд ээлтэй шийдлүүд
- БОН-ийн эрсдэлийн үнэлгээний сургалт

5. Нийгмийн хариуцлага





Нийт харилцагчийн тоо

950,000

Нийт харилцагчийн

50% эмэгтэйчүүд



Ажилтны тоо

2300

Нийт ажилтны

65% эмэгтэйчүүд



ТУЗ-ийн гишүүд болон
Газрын захирлуудын

30% эмэгтэйчүүд



Хэлтэс болон Салбарын
захирлуудын

46% эмэгтэйчүүд



Нийт
гүйлгээний

91% дижитал сувгуудаар
хийгдэх боломжтой



Corporate gateway
үйлчилгээний хэрэглэгчийн тоо

230% өссөн



Нийт
харилцагчийн

63% дижитал сувгуудаар
үйлчилгээ авч байна



СошиалПэй идэвхтэй
хэрэглэгчийн тоо

SocialPay

59% өссөн



Виртуал
картын тоо

87,358



Дижитал сувгаар хийсэн
гүйлгээний тоо

47% өссөн

АЛСЫН ХАРАА



Дэлхийн жишиг
Монголын банк

ЭРХЭМСЭГ
ОРШИХУЙ



Хөгжлийн
ГОЛОМТ

СТРАТЕГИ



Нээлттэй
банк

Бидний тухай



Монгол Улсын ууган арилжааны банкнуудын нэг Голомт банк нь 1995 онд үүсгэн байгуулагдаж, 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол өнөөдөр 2212 ажилтан, 800 мянган харилцагчтайгаар системийн 20 хувийг дангаараа бүрдүүлэн тэргүүлэгч банк болон өргөжжээ. Дэлхийн жишиг Монголын банк болох алсын хараан дор эрхэм харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд тулгуурлан орчин үеийн, дэвшилтэт технологид суурилсан санхүүгийн иж бүрэн үйлчилгээг чадварлаг, мэргэжлийн баг хамт олон, орон даяарх 100 гаруй салбар нэгжээрээ дамжуулан өндөр түвшинд хүргэн ажиллаж байна.

Бид сайн сайхныг санхүүжүүлнэ уриатайгаар улсдаа хөгжил дэвшил авчрах, үйлдвэрлэл бүтээн байгуулалтыг өрнүүлэх, бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, шилдэг бизнесүүдийг санхүүжүүлж, байгаль орчин, нийгэмд ээлтэй

үйл ажиллагааг тасралтгүй дэмжин ажилласаар ирсэн. Энэхүү үзэл баримтлалдаа бат зогсож, дэлхийн 130 банкны хамтаар НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүгийн санаачилгад нэгдэж, Монгол Улсаа төлөөлөн “Хариуцлагатай банкны зарчмууд”-ыг үндэслэгч, цор ганц банк болсноор уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тогтвортой хөгжлийн зорилтуудыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж байна.

Эдүгээ Голомт банк нь олон улсад танигдсан нэр хүндтэй, салбартаа тэргүүлэгч байр суурьтай, арвин туршлагатай, итгэлтэй найдвартай банк болон төлөвшиж, харилцагчдадаа үзүүлж буй үйлчилгээ, хэрэгжүүлж буй бүхий л санаачилга, шийдлүүд нь Монгол Улсын төр болон бизнесийн салбарт шилдэг туршлага болж жишиг тогтоон үнэ цэнийг бүтээж, Зүүн Өмнөд Ази болон Европын нэр хүндтэй, томоохон банкнуудтай эн зэрэгцэхүйц эрэмбэлэгдэж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН
ТАЙЛАН
2021

Эрхэм хүндэт та бүхэнд Голомт банкны 2021 оны Тогтвортой хөгжлийн тайланг хүргэж буйдаа баяртай байна. Энэхүү тайлангаар бид тогтвортой санхүүжилт ба тогтвортой хөгжлийн хүрээнд гаргасан ахиц дэвшил мөн тулгарсан сорилт бэрхшээлийн талаар танилцуулж байна. COVID-19 цар тахал 2021 оны турш үргэлжилж, эдийн засагт хүчтэй нөлөө үзүүлсэн бөгөөд энэ үеэр хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ харилцагч, ажилтнуудаа хамгаалах нь банкны хувьд тулгамдсан асуудал байлаа. Ажилтнуудынхаа хүчин чармайлт, харилцагчдынхаа дэмжлэгтэйгээр банк энэ сорилтыг амжилттай даван туулж, үйл ажиллагаандаа ахиц дэвшил гаргаж чадлаа. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэн, байгаль дэлхийгээ уур амьсгалын өөрчлөлтийн

сөрөг нөлөөнөөс хамгаалах нь дэлхий нийтэд бидний болон хойч үеийнхний хувьд нэн чухал зорилт болж байна. Ихэнх өндөр хөгжилтэй орнууд 2050 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг тэглэх амлалт баталсан бол Монгол Улс 2030 он гэхэд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 30 хувьд хүргэж, хүлэмжийн хийн ялгарлыг 22,7 хувиар бууруулах зорилт тавьсан. Голомт банк нь тогтвортой хөгжил болон эдгээр үндэсний хэмжээний зорилтод хувь нэмэр оруулан ажиллаж байна.

Голомт банк 2021 онд тогтвортой хөгжлийн үйл ажиллагаагаа бэхжүүлэх зорилгоор “Тогтвортой хөгжлийн стратеги 2022-2025”-ыг боловсруулж, дараах ажлуудыг хэрэгжүүллээ.

Бид Жендерийн тэгш байдлын хороо болон Тогтвортой

хөгжлийн хороо байгуулж, байгууллагынхаа тогтвортой хөгжлийн засаглалаа бэхжүүллээ. Эдгээр хороо нь Тогтвортой хөгжлийн зорилтуудыг банкны бизнест нэгтгэх, удирдан манлайлах үүрэгтэй ажилладаг. Мөн бид бүтэц зохион байгуулалтаа шинэчилж, Тогтвортой санхүүжилтийн хэлтэс байгуулж, банкны холбогдох бүх нэгжид тогтвортой хөгжлийг санаачлах, дэмжих, хянах чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

2021 онд байгаль орчин, нийгмийн (БОН) эрсдэлийн удирдлагын хүрээнд Голомт банкны БОН-ийн эрсдэлийн үнэлгээчид нийт 862 зээлийн хүсэлт буюу олгосон зээлийн 64%-д нь үнэлгээ хийв. Мөн бид бизнесийн үйл ажиллагаандаа байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээ хийж, бидний



бизнесийн нөлөөлж байгаа хамгийн чухал асуудлуудаар уур амьсгал болон усыг тодорхойлов. Иймд бид бизнесийн багцынхаа хүлэмжийн хийн ялгарал болон усны нөлөөллийг хэрхэн хэмжих талаар суралцаж, аргачлалыг тодорхойлон ажиллаж байна.

Түүнчлэн бид ногоон бизнесийн зээл, ногоон амины орон сууцны зээл, эко машины зээл гэсэн хэд хэдэн ногоон бүтээгдэхүүн шинээр хөгжүүллээ. Монгол Улсын Ногоон Таксономийн ангиллаар Голомт банкны 2021 оны ногоон зээлийн үлдэгдэл нийт зээлийн багцын 3 хувьтай тэнцэж байна. Ажилтнууд маань бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ дамжуулан харилцагчдынхаа ногоон, тогтвортой төсөл хөтөлбөрүүдийг хэрхэн дэмжиж хамтрах талаар

байнга анхаарч ажилладаг.

Бид өдөр тутмын дотоод үйл ажиллагаандаа сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ болон хог хаягдлын тогтвортой менежментийг үргэлжлүүлэн бүрдүүлж ажиллалаа. 2021 онд бид аюултай хог хаягдлын менежментээ сайжруулж, оффисууддаа 65 тусгай сав байрлуулав. Мөн одоогоор нийт 71 оффисын барилгаас 40 гаруй оффист тэргэнцрийн налуу зам болон бусад байгууламжийг тусгай хэрэгцээт үйлчлүүлэгчдэдээ зориулан барилаа. Ажилтнуудынхаа тогтвортой хөгжлийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор банкнаас 25 удаагийн сургалт зохион байгуулж, нийт 1154 ажилтан тогтвортой санхүүжилт, тогтвортой хөгжлийн чиглэлээр сургалтад хамрагдав.

Бидний тогтвортой хөгжлийн аялал үргэлжилсээр байна. Бид цаашид Тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд илүү урагшилж, гаргасан ахиц дэвшил мөн цаашид юуг илүү анхаарч хийх ёстойг ч гэсэн ил тодоор тайлагнасаар байх болно.

Бид харилцагч түншүүдийнхээ дэмжлэг, хамтын ажиллагаа, ажилтнуудынхаа тогтвортой хөгжлийн төлөө оруулсан хувь нэмэрт маш их талархаж байна.

Хүндэтгэсэн,

Гүйцэтгэх Захирал
Норихико Като

ТоС-ийн хүрээнд Голомт банкны нэгдсэн олон улсын санаачилга, хамтын амлалт

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтууд



Парисын хэлэлцээр



Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтын амлалт



Хариуцлагатай банкны зарчмууд

FINANCE
UNEP INITIATIVE

GOLOMT BANK
Investing for a brighter future

ХАРИУЦЛАГАТАЙ БАНКНЫ ҮНДСЭН 6 ЗАРЧИМ

Нийцэл

Нөлөөлөл &
Зорилтот түвшин


Харилцагч,
Үйлчлүүлэгчид

Хамтран
ажиллагчид,
Хувьцаа
эзэмшигчид,
Ажилтнууд

Засаглал
& Соёл

Ил тод
байдал
& Хариуцлага

Тогтвортой хөгжлийн он цагийн товчоо



Тогтвортой хөгжлийн стратеги 2022-2025

Голомт банк нь тогтвортой хөгжлийг стратегийн үндсэн чиглэлийн нэгээр сонгон дунд хугацаанд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг амжилттай баталж, банкны бүх түвшний үйл ажиллагааг байгаль орчин, нийгэмд ээлтэйгээр тогтвортой хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хувь нэмэр оруулах бодит зорилт тавин ажиллаж байна.

Голомт банкны 2022-2025 оны дунд хугацааны “Тогтвортой хөгжлийн стратеги” болон НҮБ-ын Хариуцлагатай банкны зарчмуудад нэгдсэн амлалтын хүрээнд дараах үндсэн зорилтуудыг тавин ажиллаж байна.

Банкны Тогтвортой хөгжлийн стратеги 2022-2025



Тогтвортой засаглал



БОН-ийн эрсдэлийн үнэлгээ



Тогтвортой санхүүжилт



Хамтын ажиллагаа, амлалтууд



Тогтвортой засаглал

Стратеги

- Тогтвортой хөгжил, тогтвортой санхүүжилтийг дэмжих сайн засаглалыг бий болгох
- Банкны бүх шатны үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн зорилтуудыг нутагшуулах

Зорилт

- Банкны Тогтвортой хөгжлийн сайн засаглалыг бүрдүүлэн, ажилтнуудын энэ хүрээнд хийсэн гүйцэтгэлийг урамшуулах, KPI-д үнэлэн тооцох
- Байгаль орчин, нийгэмд ээлтэй банкны дотоод үйл ажиллагааг өргөжүүлэх, эерэг нөлөөлөл, үр ашгийг нэмэгдүүлэх, тэдгээрийг ил тод тайлагнах
- Банкны нийт ажилтны тогтвортой хөгжлийн мэдлэг чадавхийг бэхжүүлэх, уур амьсгалын нөлөөлөл, эрчим хүчний хэмнэлт зэргийг үнэлэх бусад техник сургалт хөтөлбөрийг нэмэгдүүлэх
- Олон улсын тайлагналын стандартыг нэвтрүүлэн, Голомт банкны тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг тайлагнах

Банкны тогтвортой хөгжлийн сайн засаглалыг бүрдүүлэх суурь болгон 2021 онд Тогтвортой хөгжлийн хороо байгуулан тогтвортой хөгжлийн үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавьж, нэгж хоорондын үйл ажиллагааны уялдааг бэхжүүлэн ажиллаж байна.



Байгаль орчин, нийгмийн /БОН/ эрсдэлийн үнэлгээ

Стратеги

- Зээлийн БОН-ийн эрсдэлийн үнэлгээг сайжруулан уур амьсгалын эрсдэлийн үнэлгээг нэвтрүүлэх

Зорилт

- Зээлийн багцад уур амьсгалын үнэлгээ хийх аргачлалыг тодорхойлох, уур амьсгалын нөлөөллийн суурь тоог тодорхойлох
- Харилцагчдын уур амьсгалын эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг бууруулах зөвлөмж хүргүүлэн хамтран ажиллах

НҮБ-ын Хариуцлагатай банкны зарчим 2 “Нөлөөллийн үнэлгээ болон зорилтот түвшин”-ий хүрээнд 2021 онд Голомт банк нийт зээлийн багцад нөлөөллийн шинжилгээ хийн, банкны зээлийн багцын нөлөөлж буй байгаль орчин нийгмийн хамгийн эрсдэлтэй бөгөөд улсын хэмжээнд тулгамдсан салбаруудыг тодорхойллоо. Судалгааны үр дүнд уур амьсгал болон усны нөөцийн асуудлыг хамгийн чухал салбараар авч үзэн, эдгээрт үзүүлэх банкны нөлөөллийг бууруулах зорилт боловсруулан ажиллаж байна.



Тогтвортой санхүүжилт

Стратеги

- Банкны ногоон зээлийн багцыг нэмэгдүүлэх, олон улсын хөгжлийн санхүүгийн байгууллагуудтай тогтвортой санхүүжилтийн чиглэлд хамтын ажиллагааг өргөжүүлэх

Зорилт

- Иргэд болон ААН харилцагчдын ногоон тогтвортой худалдан авалт, төсөл хөтөлбөрүүдийг дэмжин, ногоон зээлийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх
- Ногоон зээлийн үнэлгээний тусгайлсан загвар боловсруулан ногоон зээлийг бодитоор тодорхойлж, “green washing”-оос сэргийлэх
- Ногоон зээлийн багцын байгаль орчин, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөлөл, үр ашгийг үнэлэн ил тод тайлагнах

Тайлант хугацаанд Голомт банк автомашины ногоон зээл, ногоон амины орон сууцны зээл, бизнесийн ногоон зээл зэрэг бүтээгдэхүүнийг хөгжүүлэн, харилцагчдадаа танилцуулахад бэлэн болоод байна.



Хамтын ажиллагаа, амлалтууд

Стратеги

- Тогтвортой хөгжлийг дэмжигч, хариуцлагатай банкны стандартыг хэрэгжүүлэх

Зорилт

- Дотоодын болон олон улсын тогтвортой хөгжлийн байгууллагуудтай хамтын ажиллагаа өргөжүүлэх
- Нийгэм сайн дурын үйл ажиллагааг хариуцлагатайгаар хэрэгжүүлэх

Тайлант хугацаанд Голомт банк нь Монгол Улсын Тогтвортой санхүүгийн холбоо (ТоС)-ны "Манлай банк"-аар ажиллан, санхүүгийн салбарт тогтвортой хөгжлийг нэвтрүүлэхэд идэвхтэй оролцож, ТоС холбооны дэргэдэх Жендерийн мэдрэмжтэй санхүүгийн салбар, Байгаль орчин нийгмийн эрсдэлийн үнэлгээ зэрэг ажлын хэсэгт банкны салбараа төлөөлөн ажиллалаа. Түүнчлэн 2021 оны Тогтвортой санхүүгийн форум болон ТоС-ийн салбар хэлэлцүүлгийг Голомт банк амжилттай хамтран зохион байгуулав.

ТоС холбооны үнэлгээ

“Монголын Тогтвортой санхүүгийн холбоо” нь 2016 оноос хойш нийт гишүүн банкны дунд ТоС-ийн хэрэгжилтийн үнэлгээ хийж байгаа бөгөөд 2021 оны ТоС-ийн хэрэгжилтийн үнэлгээг Монголбанк, Олон улсын Санхүүгийн корпорацитай хамтран хийж гүйцэтгэсэн. Голомт банк сүүлийн хоёр жил дараалан Тогтвортой санхүүжилтийн “А” үнэлгээ авсан билээ. ТоС үнэлгээний зөвлөмжийн дагуу бид бодлого, ногоон зээл болон бусад ногоон санхүүгийн бүтээгдэхүүн, байгаль орчин нийгмийн эрсдэлийн удирдлага зэрэгт анхаарлаа хандуулан, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллаж байна.

B+
2019

A
2020

A
2021

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр Санхүүгийн санаачилга (UNEP FI)

2021 оны НҮБ-ын Хариуцлагатай банкны зарчмуудын хэрэгжилтийн хүрээнд UNEP FI-аас гаргасан тусгай аргачлалын дагуу Голомт банк нийт зээлийн багцдаа “Impact analysis” буюу байгаль орчин уур амьсгалын нөлөөллийн шинжилгээ хийж гүйцэтгэлээ. Нийт зээлийн багцын хүрээнд impact analysis хийснээр байгаль орчин нийгмийн аль хэсэгт Голомт банкны зээлийн багц нөлөөлөл үзүүлж буйг тодорхойлох бөгөөд гарсан үр дүнд суурилан сөрөг нөлөөллийг бууруулах, эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх үүрэг хүлээж байгаа билээ. Нөлөөллийн шинжилгээгээр уур амьсгалын эрсдэл, усны нөөц зэрэгт сөрөг нөлөөллийг бууруулах зорилтуудыг боловсруулан Тогтвортой хөгжлийн хороогоор батлуулаад байна.

Тогтвортой хөгжил-2021

Засаглал



Байгууллагын Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны бүтэц



ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН
ТАЙЛАН
2021

Жендерийн хороо

Голомт банк нь жендерийн эрх тэгш байдлыг дотооддоо ханган ажиллах зорилгоор 2018 онд Жендерийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг боловсруулсан. Улмаар ажлын байранд үүсэх харилцаанд жендерийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэн, ажилтан бүр банкны үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцож, байгууллагын тогтвортой хөгжлийг дэмжин ажиллаж байна.

Мөн Голомт банкны ТУЗ болон Удирдлагын багийн гишүүд жендерийн эрх тэгш байдлыг дотооддоо ханган ажиллахаас гадна эмэгтэй харилцагчдын хувьд жендер, түүнийг дагасан эдийн засгийн хөгжлийн асуудалд илүү анхааран ажиллах зорилгоор “Gender equality committee” буюу “Жендерийн тэгш байдлын хороо”-г 2020 онд байгуулсан.

“Жендерийн тэгш байдлын хороо” нь ажлын байранд жендерийн тогтвортой, эрх тэгш байдлыг хангаж, эмэгтэй бизнес эрхлэгчдэд санхүүгийн үйлчилгээг илүү хүртээмжтэй, ахисан түвшинд хүргэх зорилгоор банкны бодлого, стратеги, үйл ажиллагаанд анхааран ажиллаж байна.

Тогтвортой хөгжлийн хороо

Голомт банк нь “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” болон “Үндэсний зорилтот хувь нэмэр”-ийг дэмжин ажиллахын зэрэгцээ тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг үйл ажиллагааны шат бүхэнд хэвшүүлэх зорилгоор топ удирдлагын багийн бүрэлдэхүүнтэйгээр 2021 оны 11 дүгээр сард “Тогтвортой хөгжлийн хороо”-г анх байгуулсан.

“Тогтвортой хөгжлийн хороо” болон “Жендерийн хороо” нь НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр санхүүгийн санаачилгаас гаргасан “Хариуцлагатай банкны зарчмууд”-ыг тогтвортой бизнесийн үйл ажиллагаа явуулах, нийгэм, байгаль орчны асуудлуудад анхаарал хандуулах, тогтвортой, сэтгэл ханамжтай ажлын байр бий болгох зэрэг стратегийн үндсэн чиглэлийг бүхий л үйл ажиллагаандаа уялдуулан, хэрэгжүүлэн ажиллахыг зорьж байна.

Тогтвортой санхүүжилтийн хэлтэс

Тогтвортой санхүүжилтийн хэлтэс нь банкны Тогтвортой хөгжлийн бодлого, стратеги болон түүний хэрэгжилт, тайлагналд хяналт, шаардлага тавин ажиллахын зэрэгцээ тогтвортой санхүүжилтийг бүрдүүлэн “Хариуцлагатай банкны зарчмууд”-ыг нийт банкны хэмжээнд таниулах, хэрэгжилтийг хангуулан ажиллах үүрэгтэй хэлтэс юм. Анх уг үүргийг Төслийн санхүүжилтийн хэлтэс, түүний дараа Санхүүгийн хөгжлийн хэлтэс хариуцаж байсан бөгөөд Голомт банкны ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын саналаар тогтвортой хөгжлийг эрчимтэй дэмжин ажиллах зорилгоор 2021 онд “Тогтвортой санхүүжилтийн хэлтэс” -болгон шинэчилж байгуулсан.

Тус хэлтэс нь 2021 онд Голомт банкны “Тогтвортой хөгжлийн стратеги 2025”-ыг боловсруулж “Тогтвортой хөгжлийн хороо”-гоор батлуулсан бөгөөд стратегийн хэрэгжилтэд хяналт, шаардлага тавин ажиллахын зэрэгцээ “Тогтвортой хөгжлийн хороо” болон “Жендерийн эрх тэгш байдлын хороо”-ны үйл ажиллагаа, хороодын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Комплаенсийн бодлого

Комплаенсийн хэлтэс нь банкны Ерөнхийлөгчийн шууд удирдлагад ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын багт ажлаа тайлагнадаг бөгөөд ерөнхий комплаенсийн холбогдох асуудлууд болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндсэн чиг үүргийг хариуцдаг нэгж юм.

Голомт банк 2017 оноос хойш ТУЗ-өөр баталсан Комплаенсийн бодлогын дагуу Засаглалын кодекс дахь зарчим, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах, хянах, ёс зүйн зөрчлийг арилгах зорилго бүхий Ёс зүйн төлөөлөгчдийг бүх нэгжээс томилон, нийт 148 хүн ажиллуулж байна.

Банкны Комплаенсийн дотоод хяналтын хөтөлбөрт ажилтнуудын мэдлэг маш чухал байр эзэлдэг. Тиймээс банкны бүх түвшний ажилтанд комплаенс, тэр дундаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар цогц хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулдаг. 2021 онд банкны хэмжээнд нийт давхардсан тоогоор 1072 ажилтан уг сургалтад суусан байна.

Голомт банк нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг удирдах чиг үүргийн хүрээнд гүйлгээний хяналтыг хэрэгжүүлэх тусгайлсан програм ашигладаг бөгөөд хуулиар хүлээсэн үүргээ хангалттай түвшинд гүйцэтгэж ажиллаж буй юм. Мөн харилцагч таньж мэдэх, гүйлгээний хяналтыг хэрэгжүүлэх, мэдээлэх болон шүгэл үлээх үйл ажиллагааг тус тусын журам, стандартаар зохицуулан ажилладаг.

Мэдээллийн аюулгүй байдлын бодлого

Голомт банк мэдээллийн аюулгүй байдалдаа онцгойлон анхаарч, найдвартай, итгэлтэй үйлчилгээ үзүүлж, олон улсын нэр хүнд бүхий ISO27001, төлбөрийн картын аюулгүй байдлын PCI-DSS стандарт болон Хувь хүний өгөгдөл хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах GDPR буюу Европын холбооны Хувь хүний өгөгдөл хамгаалах тухай хуулийн бүх шаардлагыг ханган, үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлж байна.

Мөн Банкны систем рүү чиглэсэн гадны кибер халдлагаас хамгаалах зорилгоор Security operations maturity model (SOMM) стандартын шаардлагуудыг бүрэн хангасан Кибер аюулгүй байдлын удирдлагын төвийг (КАБУТ) байгуулсанаас гадна дэлхийн 1100 гаруй байгууллага нэгдсэн кибер аюулгүй байдлын олон улсын хамтын ажиллагааны төсөл болох Парисын Кибер орчин дахь аюулгүй байдлыг хангах харилцан итгэлцлийн уриалгад нэгдээд байна.

Голомт банкны Кибер аюулгүй байдлын үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ сүүлийн 3 жил тасралтгүй өссөн байна.

2021 онд нийт  **10 сая** халдлагаас хамгаалснаар  **4-3,71** гэсэн үнэлгээ аваад байна.

"Энэхүү үнэлгээг Хонгконг болон Энэтхэгийн аудитор компаниудын тайлан дээр үндэслэж дотооддоо гаргадаг."

Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр баримталдаг олон улсын стандартууд



Байгаль орчин, нийгмийн /БОН/ эрсдэлийн менежмент

БОН-ийн эрсдэлийн үнэлгээний бодлого


Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд Голомт банк нь зээл, төслийн шийдвэр гаргахдаа байгаль орчин, нийгмийн эрсдэлийг харгалзан үзэх ба уг эрсдэлийг удирдах боломжтой гэж үзсэн тохиолдолд зээл олгох, төслийг санхүүжүүлэх зарчим баримтлан ажиллаж байна. Бид 2019 онд байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний аргачлалыг IFC, Монголбанк болон тогтвортой хөгжлийн зарчмуудыг тусган шинэчилсэн бөгөөд ингэснээр байгаль орчин, хүний эрх, нийгэм, соёлын өвийг тус тус хамгаалах, ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих, манлайлан үлгэрлэх, эрсдэлийн үнэлгээний мэдээллийн бааз бий болгох, улмаар эрсдэлийг мэдээлэх, тайлагнах, хянах боломж бүрдүүлэх зорилгоор үнэлгээг системд нэвтрүүлсэн.

2021 онд нийт үнэлсэн зээлийн хувь, эрсдэлийн зэргийн ангилал

2021 онд Голомт банк нийт 1340 бизнесийн зээл олгосны 64 хувьд байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байна. Нийт зээлийн 298 нь байгаль орчин, нийгмийн хувьд “эрсдэлтэй” гэсэн ангилалд багтдаг барилга, боловсруулах үйлдвэрлэл, уул уурхай, дэд бүтэц, шатахуун химийн бодисын худалдаа зэрэг үйл ажиллагаа явуулдаг салбарт ногдож байгаа юм. Бид “эрсдэлтэй” ангилалд олгосон 298 зээлээс 213-т нь БОН эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.

“Эрсдэлтэй” зээлийг дотор нь А, В, С гэж ангилдаг бөгөөд Голомт банк 2021 онд нийт 354 зээлд (2020 онд үнэлж, 2021 онд олгосон зээлийн тоог оруулаад) БОН эрсдэлийн үнэлгээ хийж, үүнээс 213-ыг нь олгожээ. Олгосон 213 зээлээс 8 нь өндөр эрсдэлтэй буюу А, 92 зээл дунд эрсдэлтэй буюу В, 113 зээл С буюу бага эрсдэлтэй ангилалд орсон байна. 2022 оноос бид А буюу хамгийн өндөр эрсдэлтэй гэсэн үнэлгээ авсан тохиолдолд зээл огт олгохгүй байх зорилт тавин ажиллаж байна.

2021 онд олгосон зээлд Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал



Эрсдэлийн зэргээр үнэлсэн болон олгосон нийт зээл /тоогоор/



Олгосон зээл /эрсдэлийн ангиллаар/



Тогтвортой санхүүжилт



Хөрөнгө оруулалт, эх үүсвэр

Гадаад худалдааны санхүүжилтийн уян хатан боломжууд, хямд өртөг бүхий гадны эх үүсвэрийг харилцагчдадаа санал болгох зорилгоор Голомт банк сүүлийн жилүүдэд олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхтэй өргөжүүлж, санхүүжилт болон зээлийн шугамуудаа нэмэгдүүлсээр ирсэн.

Сүүлийн жилүүдийн дундаж эх үүсвэрийн татан төвлөрүүлсэн байдал



Энэхүү дунд болон урт хугацааны санхүүжилтийн шийдлийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгч харилцагчдадаа санал болгож, улмаар бизнес эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засгийн хөгжлийг дэмжих томоохон ач холбогдолтой билээ.

Харилцаа, хамтын ажиллагаатай гадаадын банк санхүүгийн байгууллагууд




Ногоон санхүүжилт

2019 оны 12 дугаар сард Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралдаанаар Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо болон Хадгаламжийн даатгалын корпорациас хамтарсан тушаал гаргаж, Монгол Улсын “Ногоон Таксономи”-ийг баталсан. “Ногоон Таксономи” нь байгаль, орчин нийгэмд ээлтэй ногоон үйл ажиллагааны ангилал, шалгуур үзүүлэлт бөгөөд банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон бодлого боловсруулагчид ашиглан ногоон зээл төсөл хөтөлбөрүүдийг тодорхойлох боломжтой болсон.

“Ногоон Таксономи”-ийг баталснаар Монгол Улсын арилжааны банкнууд 2020 оны 1-р улирлаас эхлэн өөрсдийн ногоон зээлийг ангилан, сайн дураар Монголбанканд тайлагнаж эхэлсэн билээ. Голомт банк ч мөн адил улирал бүр ногоон таксономийн дагуу ногоон зээлийн багцаа тайлагнан, хэмжээг нь жил бүр нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Ногоон зээлийн багцын үлдэгдэл /сая төгрөгөөр/



24,322.82 сая₮

Тогтвортой ус,
хаягдлын
хэрэглээ

31,537.74 сая₮

Тогтвортой хөдөө аж ахуй,
газар ашиглалт, ой болон
эко аялал жуулчлал

649.59 сая₮

Карбон
бага тээвэр

97,754.19 сая₮


Нийт
зээлийн багц

Жендерийн санхүүжилт


Монгол Улсын жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 60-аас дээш хувийг эмэгтэйчүүд эзлэн, эдийн засгийн гол тулах хүч болон ажиллаж, баялаг бүтээн, ажилгүйдлийг бууруулахад хувь нэмрээ оруулсаар байна. Голомт банкны нийт харилцагчийн 50 орчим хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн санхүүгийн боловсролын түвшин нэмэгдэж, банкны төлбөр тооцоо болон зээлийн үйл ажиллагаанд оруулах хувь нэмэр жилээс жилд өсөж байна. Тиймээс бид бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжин санхүүгийн хувьд улам чадавхжуулж, үйлдвэрлэл үйлчилгээ идэвхтэй эрхлэх боломжоор хангаж байна.

Нийт харилцагчийн хүйсийн харьцаа


2019



2020




2021




Нийт зээлдэгчийн хүйсийн харьцаа


2019



2020



2021



Эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан сургалт хөтөлбөрүүд, хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүн

Бизнесийн орчныг сайжруулах, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, бүтээмжийг дээшлүүлэхийг Голомт банкны хамт олон зорин ажилладаг. Тэр дундаа эмэгтэй бизнес эрхлэгчдээ дэмжин хөнгөлөлттэй зээл олгох, санхүүгийн боловсролыг дэмжих цуврал сургалт зохион байгуулдаг. 2021 онд “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах хөтөлбөр” хэрэгжүүлж, 5 дугаар сарын 19-нөөс он дуустал хугацаанд нийслэл болон орон нутгийн бизнес эрхлэгч нийт 400 орчим эмэгтэйг санхүүгийн цогц удирдлага, хямралын үеийн санхүүгийн удирдлага, Татварын тухай хуулийн хэрэглээ, онлайн төлбөр, дижитал маркетинг, харилцааны ур чадвар, байгаль орчны үнэлгээ, хог хаягдлын менежмент зэрэг олон цуврал сургалтад хамрууллаа.

Мөн эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулан хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүн гаргаж 2021 онд худалдаа, үйлчилгээ болон бусад салбарт нийт 1.4 тэрбум төгрөгийн зээлийг эмэгтэй бизнес эрхлэгчдэд олгож, тэдний бизнесийг дэмжсэнээр бүтээгдэхүүн, үйлчилгээнийх нь чанарыг илүү сайжруулж чадлаа.

ЖДҮ санхүүжилт

Голомт банк жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжихэд ихээхэн ач холбогдол өгч, энэ хүрээнд дараах гол зорилгыг тавьж буй юм. Үүнд:


- Сегментэд суурилсан бүтээгдэхүүний багцын борлуулалтыг нэмэгдүүлэх
- Харилцагчдадаа мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх
- Дижитал шилжилтийг эрчимжүүлэх
- ББСБ-д суурилсан бизнесийн шинэ загварыг нэвтрүүлэх

Стратегийн хувьд байгууллагад чиглэсэн, тогтвортой бизнес эрхлэгч иргэн, жижиг бизнес эрхлэгч, үйл ажиллагаа нь бүрэн тогтворжиж амжаагүй буюу богино хугацаанд бизнес эрхэлсэн иргэн, аж ахуйн нэгжүүд гэсэн чиглэлээр бид хэрэгжүүлэх ажлаа тодорхойлоод буй юм. Энэ хүрээнд бизнес идэвхтэй байгаа үед зээлийн багцыг тэлэх, тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгох, судалгаанд үндэслэн шинэ харилцагчдыг татах, зээлийн чанар, тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, бизнесийн зах зээлийн судалгааг тогтмол хийж шийдвэр гаргах зэргээр ажиллаж байна. Мөн техник, технологийн шийдлээр тэргүүлэгч банкны хувьд жижиг, дунд бизнес эрхлэгч бүрийг интернэт банк, SocialPay үйлчилгээний хэрэглэгч болгох, ПОС-ын тоо, хэрэглээ, цахим худалдааны үйлчилгээг нэмэгдүүлэхийг зорьж буй юм. Ингэснээр хэрэглэгчдийн цаг завьг бүрэн хэмнэж, үйлчилгээгээ түргэн шуурхай хүргэх, авах боломж бүрдэх билээ.

ЖДҮ багцын өсөлт, сегмент болон эдийн засгийн салбарын ангилал

Голомт банк жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулан нийт 826 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өмнөх онохоос 20 хувиар өссөн үзүүлэлт юм. Бид ЖДҮ эрхлэгчдэд эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх, эргэн төлөлтийн ачааллыг бууруулах, нэмэлт барьцаа хөрөнгө шаардахгүйгээр одоогийн үнээр бараа материалаар баталгаажсан зээл авах зэрэг шинэ бүтээгдэхүүн санал болгон ажиллаж байна.

2021 онд ЖДҮ салбарт олгосон зээл /салбараар/



Ковид-19 цар тахлын үед авч хэрэгжүүлсэн Засгийн газрын төсөл хөтөлбөрүүд

2021 онд Ковид-19 цар тахал дэлхий нийтээр үргэлжилж, эдийн засаг, банк санхүү, нийгмийн амьдралд олон сөрөг нөлөө, сорилт авчирсан. Засгийн газар болон Монголбанкнаас энэ хугацаанд зохицуулалтын тодорхой арга хэмжээ авлаа. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газраас “Эдийн засгаа сэргээх 10 их наяд төгрөгийн цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлснээр хөтөлбөрийн болон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зээл, репо санхүүжилтээр нийт банкны салбарт 4.3 их наяд төгрөгийн зээл олгож, жилийн 5 хувиар буураад байсан нийт банкны системийн зээл 20.7 их наяд төгрөгт хүрсэн байна.

Ковидын үед банкны авч хэрэгжүүлсэн арга хэмжээ



Голомт банкны тухайд ковидын нөхцөл байдлын үед байгууллагын, бичил болон жижиг дунд, хэрэглээний, орон сууцны зэрэг чиглэлээр олгосон зээлийн эргэн төлөлтөд зарим зохицуулалт хийж ажиллажээ.

Төсөл хөтөлбөрийн санхүүжилт, БОН-д ээлтэй төслийн зээлийн хөтөлбөрүүд

Голомт банк 2021 онд байгаль орчин, нийгэмд ээлтэй, эерэг үр дагавартай төслүүдтэй хамтран ажиллаж, нийт 149.8 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Тухайлбал, ноос, ноолуурын салбарын төсөлд хамгийн их буюу 22.9 тэрбум, Азийн хөгжлийн банкны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төсөлд 6.5 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгосон байна.

Төсөл хөтөлбөрийн зээлийн олголт 2021 он

Жайка төсөл	695 сая ₮	АХБ-ны ХАА хөдөөгийн хөгжлийг дэмжих төсөл	6.5 тэрбум ₮	КФВ банкны төсөл	500 сая ₮	Махны нөөц бүрдүүлэх төсөл	3.4 тэрбум ₮
“Алт-2” хөтөлбөр	77.6 тэрбум ₮	Улаанбуудайн нөөц бүрдүүлэх	2 тэрбум ₮	АХБ-ны Эх үүсвэртэй батлан даалттай зээл	2.5 тэрбум ₮	Ноолуур, ноос бэлтгэл	22.9 тэрбум ₮
Хаврын тариалалт	1.1 тэрбум ₮	Арьс шир	1.5 тэрбум ₮	Улаанбуудай, тосны ургамал	3.8 тэрбум ₮	Шатахууны нөөц бүрдүүлэх	27.1 тэрбум ₮


ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН
ТАЙЛАН
2021

Дижитал банк

Голомт банк дижитал шилжилт, мэдээллийн технологийн дэвшилд суурилсан үйлчилгээгээр салбартаа тэргүүлж, энэ чиглэлд түлхүү хөрөнгө оруулж ажилладаг. 2021 онд бид мэдээллийн технологийн хэд хэдэн Монгол компанитай хамтран дижитал шилжилт хийхэд анхаарлаа.



Харилцагчдын дижитал банкны хэрэглээ



Тогтвортой үйл ажиллагаа, Хүний нөөцийн удирдлага



Ковид-19 цар тахлын үед банкны авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

Цар тахлын эрсдэл нь байгууллагуудад өөрийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээнд дижитал шилжилтийг хийх хурдасгуур болж өгсөн. Банкны хувьд бизнесийн тасралтгүй ажиллагаа төлөвлөгөөг идэвхжүүлэн үйл ажиллагаагаа бүрэн зайнаас хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ дижитал сувгуудаар дамжуулан хүргэх сайжруулалтуудыг амжилттай нэвтрүүлээ.

- Эрсдэлийн засаглал, “Гурван шугамын загвар”, эрсдэл даах чадвар, стресс тестийн үр дүнд суурилсан эрсдэл даах чадварын нөөц интервал бүрдүүлэлт, эрсдэлийн аппетитийн мэдэгдэл, гэрлэн дохионы аргачлал зэрэг Эрсдэлийн удирдлагын тогтолцоонд хамаарах үндсэн бүрэлдэхүүнийг улам төгөлдөржүүлж, дотооддоо мөрдөн ажиллаж байна.
- Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос гаргасан өөрийн хөрөнгийн хүрэлцээний дотоод үнэлгээний аргачлал (ICAAP)-ыг банк дотооддоо тооцож нэгтгэсэн стресс тестэд ашиглах замаар холбогдох хороонд танилцуулан өөрийн хөрөнгийн хяналтыг хэрэгжүүлж байна.
- Бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө болон түүнд нийцүүлэн гаргасан дэд төлөвлөгөөнүүдийн хүрээнд шуурхай ажиллах багийн зохион байгуулалтад шилжиж, өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэн цар тахлын эрсдэлийг амжилттай даван тууллаа.
- Эрсдэлийн соёлыг банканд төлөвшүүлэх зорилгын хүрээнд эрсдэлийн удирдлагын цогц сургалт, форум, мэдлэг сорих уралдаан тэмцээн зохион байгуулж, эрсдэлийн соёлын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүллээ.
- Сэтгэл зүйн болон биеийн эрүүл мэндийн цуврал сургалт, контент, витаминжуулалтын аян зэргийг ажилтнууддаа жилийн турш тогтмол зохион байгуулж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ хүргэлээ.


Сэтгэл ханамжтай, тогтвортой ажлын байр

Цар тахал багагүй сорилт шалгуур авчирсан ч Голомт банк ажилтнуудынхаа ажлын байрыг тогтвортой хадгалахаас гадна цалин, хангамж, урамшууллыг тухай бүрт тасалдуулалгүй өгөх замаар нийгмийн асуудлыг дэмжиж, улмаар 2021 онд шинээр 570 ажилтанг эгнээндээ элсүүллээ. Бодитоор ажиллаж буй 1916 ажилтан байгаагийн 65 хувь нь эмэгтэйчүүд бөгөөд нийт ажилтны 84.5 хувь нь 1-ээс дээш жил тогтвортой ажиллаж байна. Мөн тусгай хэрэгцээт иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг Голомт банк дэмжин ажилладаг бөгөөд сүүлийн 3 жилд тусгай хэрэгцээт ажилтны тоо тасралтгүй өслөө.



Удирдах, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хүйсийн тэгш эрхийг хангах нь бидний баримталдаг нэг гол зарчим юм. Голомт банкны ТУЗ-ийн гишүүд болон Газрын захирлуудын 30 хувийг чадварлаг бүсгүйчүүд бүрдүүлдэг. Хэлтэс болон салбарын захирлуудын түвшинд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харьцаа 52:48 буюу бараг тэнцүү байна.

Голомт банкны нийт ажилтны хүйсийн харьцаа



ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН
ТАЙЛАН
2021

Ажилтнуудад зориулсан сургалт, тэтгэмж, хөнгөлөлт

Голомт банкны Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд баримтлах нэг стратеги бол сэтгэл ханамжтай, тогтмол ажлын байр бий болгох явдал. Тиймээс бид нийт банкны сургалт, хөгжлийн модельд үндэслэн “Ажилтан Та хөгжлийн голомт” уриатайгаар нийт ажилтныхаа тасралтгүй сурч хөгжих, сурсан мэдлэгээ бусадтай хуваалцах боломжийг бүрдүүлж, “Сургалтын академи”-ийг үүсгэн байгууллаа. Бид ажилтнууддаа биетээр болон дижитал сувгаар сургалтуудаа хүргэдэг.



Бид нийт 1700 гаруй ажилтнаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт, 1200-аад ажилтныг ковидын давхар даатгал, вакцинжуулалтад бүрэн хамрууллаа. Мөн 2021 онд нийт 937 ажилтанд хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж олгосон бөгөөд Голомт банкнаас 5 ажилтан тэтгэвэртээ гарсан байна.

Тогтвортой хөгжлийн сургалт

Голомт банк Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд ажилтнуудынхаа байгаль орчин, нийгэм, хүний тэгш эрхийг хангах чиглэлээр мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч ажилладаг бөгөөд 2020 онд бид нийт ажилтныхаа 80 хувийг тогтвортой хөгжил, ногоон санхүүжилт, байгаль орчин нийгмийн эрсдэлийн үнэлгээний талаар ойлголт, мэдээлэл өгөх сургалтад хамруулж байв. Үүний үр дүнд ажилтнуудын энэ чиглэлээрх мэдлэг, ойлголт тэлж, өдөр тутмын үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгмийн асуудалд илүү анхаарч, улмаар бид дотооддоо хогоо ангилах, цахилгаан хэмнэх тал дээр олон дэвшил гаргаж чадсан. 2021 онд бид 1154 орчим ажилтнаа энэ чиглэлээр сургалтад хамрууллаа.

Тогтвортой хөгжлийн сургалтад хамруулсан ажилтнууд

2021 онд Тогтвортой хөгжлийн сургалтад  **1154** ажилтныг хамруулав

Байгаль орчинд ээлтэй шийдлүүд

Тогтвортой хөгжлийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хязгаарлахын тулд бид дотоод үйл ажиллагаандаа системтэйгээр арга хэмжээ авч, нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулахад голлон анхаарч ажиллаж буй юм.

Эрчим хүчний хэрэглээ нь хүлэмжийн хийн ялгарлыг их хэмжээгээр нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд гол сөрөг нөлөө үзүүлдэг. Тиймээс Голомт банк цахилгаан эрчим хүчийг хэмнэхэд анхаарч, барилгын дулаан алдагдлыг бууруулж, цахилгаан бага зарцуулдаг лед гэрэл сонгон хэрэглэх болсон бөгөөд 3-р оффистоо сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж суурилуулсан нь тодорхой үр дүнд хүрээд байна.

2021 онд 4,897 тонн буюу өмнөх оноос 30 хувиар бага ус хэрэглэж, хэмнэлт хийжээ. Голомт банк салбар тооцооны төвүүддээ дахин боловсруулах хог хаягдлыг бөөгнүүлэн, үйлдвэрүүдэд тушаадаг туршлагыг 2 дахь жилдээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

 Банкны 3-р оффист цахилгааны хэрэглээ 2021 онд **161.405** кВт өмнөх оныхоос **19.1%** буурчээ.

 2021 онд **4.897** тонн буюу өмнөх оныхоос **30%** бага ус хэрэглэжээ.

Цахилгааны хэрэглээ /кВт-аар/

205,586.60 | 99,716.50 | 161,405.70
2019 | 2020 | 2021

Нийгмийн хариуцлага



“Зүрх мартаггүй” төсөл



Голомт банкны
“Алтантүлхүүр”
хүүхдийн сан “Зүрх

мартахгүй” төслийг 2 дахь жилдээ дэмжин хамтран ажиллаж, 20 гаруй бяцхан зүрхэнд амьдрал бэлэглээд байна. Бид хүүхдүүдийн мэс заслын төлбөрийг санхүүжүүлэхээс гадна төслийн багийнханд шаардлагатай бүх дэмжлэгийг үзүүлэн ажиллаж буй юм.



Тусгай хэрэгцээт сурагчдын тэгш эрхийг хангав

Сайн сайхныг санхүүжүүлэгч Голомт банк тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сурах тэгш эрхийг хангах зорилгоор харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн 116 дугаар сургууль болон оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийн 25 дугаар сургуульд тус тус мэдээллийн технологийн хичээлийн танхимыг бүрэн засварлаж, холбогдох тоног төхөөрөмж хандивлалаа. Мөн “Орбит рийдер” буюу цахим брайл төхөөрөмжийг 116 дугаар сургуульд хандивласнаар тусгай хэрэгцээт боловсролын сургалтын системд анх удаа монгол хэлтэй брайл төхөөрөмж нэвтрүүлсэн түүхэн алхам болсон. Улмаар харааны бэрхшээлтэй хүүхдүүд цахим брайл төхөөрөмжийг ашиглан компьютер, интернэтийн програмуудыг бусдын тусламжгүйгээр ашиглан сурч, хөгжих, цаашлаад энгийн сургуульд ч суралцах боломж бүрдсэн юм. Түүнчлэн 25 дугаар сургуулийг ухаалаг самбартай болгосноор оюуны бэрхшээлтэй хүүхдүүд харах мэдрэмжээрээ дамжуулан илүү амжилттай сурах боломжтой боллоо.



Хүний тэгш эрхийг хангах зорилтын хүрээнд бид салбарууддаа тусгай хэрэгцээт иргэд үйлчлүүлэх боломжийг хангах ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлсээр байна. Одоогоор Голомт банкны нийт 40 салбарт тэргэнцрийн налуу зам тавиад байгаа бөгөөд 6 салбарт шаардлагатай үед хэрэглэх тэргэнцэр байрлуулсан. Мөн тусгай хэрэгцээт иргэн, бага насны хүүхэдтэй хүн, өндөр настан, жирэмсэн эмэгтэйчүүдэд дугааргүй үйлчлэх цонхыг бүх салбартаа ажиллуулж байна.

Оюутны тэтгэлэгт хөтөлбөр

Боловсролыг дэмжигч Голомт банк нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр хэрэгжүүлдэг “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-өө 17 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

Хөтөлбөрт 700 гаруй оюутан материалаа ирүүлснээс МУИС, СЭЗИС, ШУТИС, АШУУИС, ХУИС, “Отгонтэнгэр”, “Этүгэн” зэрэг нийт 26 их, дээд сургуулийн 100 оюутан шилдгээр шалгарлаа.

Голомт банк оюунлаг залуусын

сурах хүсэл эрмэлзлийг мэргэжил харгалзахгүй дэмжиж, эдүгээ нийт 1500 гаруй оюутанд нэг тэрбум гаруй төгрөгийн тэтгэлэг олгож, сурч хөгжих, чанартай боловсрол эзэмшихэд нь хөрөнгө оруулаад байна.



Тоон мэдээлэл

Дижитал банк


	2019	2020	2021
Дижитал сувгийн /Интернэт банк, Смарт, СошиалПэй/ нийт хэрэглэгчийн тоо	437,843	520,141	619,422
СошиалПэй нийт хэрэглэгчийн тоо	181,979	229,939	290,759
Дижитал сувгийн идэвхтэй хэрэглэгчийн тоо	165,835	200,644	259,714
Дижитал сувгийн гүйлгээний тоо	15,947,331	21,544,961	31,622,664
Нийт CDM (ATM with Smart functionality)	58	69	151

Мэдээллийн аюулгүй байдал


	2019	2020	2021
Кибер халдлагын тоо			
Кибер аюулгүй байдлын үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ (дээд үнэлгээ 4)	2.2/4	2.4/4	3.71/4
Хамгаалсан халдлагын тоо	2,1 сая	3.6 сая	10 сая
Ажилтны аюулгүй байдлын мэдлэг			
МАБ шалгалтанд хамрагдсан байдал	98%	95%	97%
МАБ шалгалтын үнэлгээ	88%	93%	88%
Олон улсын МАБ стандарт нэвтрүүлсэн байдал			
ISO 27001	+	+	+
Payment Card Industry Data Security Standard (PCI DSS)	+	+	+
General Data Protection Regulation (GDPR)	+	+	+
Security Operations Maturity Model (SOMM)	+	+	+

2021 онд хийсэн байгаль орчин, эрсдэлийн үнэлгээ


2021 онд олгосон зээлийн хувьд БОН эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал



БОНЭ үнэлгээ хийсэн болон олгосон зээл /эрсдэлийн зэргээр/



2021 онд БОН-ийн эрсдэлийн үнэлгээ хийсэн зээл хүсэлтээс олгосон тоон үзүүлэлт



Зээлийн үлдэгдэл

1. Сегментээр /Сая.₮/

	2019		2020		2021	
Байгууллагын зээл	1,343,976	40.8%	1,196,494	39.0%	1,191,571	34.8%
ЖДҮ	637,212	19.3%	631,547	20.6%	795,112	23.2%
Хэрэглээний зээл	903,119	27.4%	752,420	24.6%	773,191	22.6%
Орон сууцны зээл	398,704	12.1%	479,144	15.6%	656,427	19.2%
Overdraft	10,286	0.3%	5,167	0.2%	4,593	0.1%
Нийт	3,293,297	100.0%	3,064,772	100.0%	3,420,894	100.0%

2. Салбараар /Сая.₮/

	2019		2020		2021	
Бизнесийн зээл	1,991,474	60.5%	1,833,208	59.8%	1,991,276	58.2%
Бөөний болон жижиглэн худалдаа	498,171	15.1%	493,367	16.1%	739,101	21.6%
Уул уурхай	261,650	7.9%	414,758	13.5%	325,661	9.5%
Үйлдвэрлэл	396,004	12.0%	272,260	8.9%	205,294	6.0%
Засвар үйлчилгээ	32,808	1.0%	57,865	1.9%	202,104	5.9%
Барилга	387,019	11.8%	252,791	8.2%	137,095	4.0%
Санхүү	150,790	4.6%	136,792	4.5%	101,696	3.0%
Олон улсын байгууллага	-	0.0%	-	0.0%	87,828	2.6%
Тээвэр, харилцаа холбоо	103,171	3.1%	61,233	2.0%	60,711	1.8%
Үл хөдлөх хөрөнгө	21,602	0.7%	34,010	1.1%	32,120	0.9%
Зочид буудал, Ресторан	38,789	1.2%	31,937	1.0%	30,896	0.9%
Хөдөө аж ахуй	25,758	0.8%	18,375	0.6%	17,524	0.5%
Эрүүл мэнд	25,504	0.8%	19,324	0.6%	16,775	0.5%
Боловсрол	13,006	0.4%	11,739	0.4%	13,521	0.4%
Цахилгаан холбоо	17,158	0.5%	15,574	0.5%	12,720	0.4%
Overdraft	10,286	0.3%	5,167	0.2%	4,593	0.1%
Нийгмийн үйлчилгээ	1,157	0.0%	909	0.0%	1,783	0.1%
Аялал жуулчлал	7,036	0.2%	6,657	0.2%	1,689	0.0%
Бизнес эрхлэлт	476	0.0%	412	0.0%	164	0.0%
Нийтийн үйлчилгээ	1,090	0.0%	37	0.0%	-	0.0%

3. Дундаж зээлийн хэмжээ /Сая.₮/

	2019	2020	2021
Байгууллагын зээл	3,131.7	3,520.6	3,631.4
ЖДҮ	135.1	161.1	172.5
Хэрэглээний зээл	7.1	5.6	5.6
Орон сууцны зээл	65.8	68.4	80.1
Нийт	25.9	22.8	23.8

4. Хот болон хөдөөгийн байршлаар /Сая.₮/

	2019	2020	2021
Хот салбар	2,752,928	2,601,848	2,951,595
Байгууллагын зээл	1,352,901	1,200,536	1,194,731
ЖДҮ зээл	527,780	533,270	671,731
Хэрэглээний зээл	534,741	461,194	515,580
Орон сууцны зээл	337,506	406,848	569,554
Хөдөө салбар	432,150	387,118	408,277
ЖДҮ зээл	110,794	99,402	124,815
Хэрэглээний зээл	260,159	215,420	196,589
Орон сууцны зээл	61,197	72,296	86,873
Нийт	3,185,078	2,988,966	3,359,872

Жендерийн санхүүжилт /Сая.₮/

Эдийн засгийн салбар	Олгосон зээлийн дүн (MNT)	Зээлийн үлдэгдэл дүн (MNT)	Дансны тоо	Зээлийн хугацаа (сар)	Хүүний хувь (жил)
Боловсруулах үйлдвэрлэл	100	100	1	12	13.2%
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	818	740,1	27	27	13.7%
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	36,1	32,5	2	27	13.2%
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	20	20	1	12	14.4%
Худалдаа	636,1	591,9	23	28	13.6%
Нийт	1,610,2	1,484,6	*54	*27	*13.6%

* дундаж

Төслийн зээлийн багц /Сая.₮/

Төслийн нэр	Харилцагчийн тоо	Олгосон зээлийн тоо	Олгосон зээлийн дүн (MNT)
"Алт 2" /урт хугацаат санхүүжилт/	8	9	54,704
Шатахууны нөөц бүрдүүлэх хөтөлбөр 2022	2	2	27,100
"Алт 2" урьдчилгаа төлбөрийн санхүүжилт	4	4	22,920
Ноолуур, ноос бэлтгэл 2021	2	2	22,900
АХБ-ХААХХ төслийн зээл	2	2	6,500
Улаанбуудай, тосны ургамал 2021	2	2	3,865
Махны нөөц бүрдүүлэх 2021-2022	2	2	3,441
АХБ-ны эх үүсвэртэй ЗБДС-гийн батлан даалттай зээл	4	4	2,520
Улаанбуудайн нөөц бүрдүүлэх	1	1	2,000
Арьс шир 2021	1	1	1,500
Хаврын тариалалт 2021	3	3	1,190
Жайка төслийн зээл	1	1	695
КФВ банкны төслийн зээл	1	1	500
Нийт	33	34	149,835

Голомт банкны нийт харилцагчийн хүйсийн харьцаа

	2019	2020	2021	Хэмжих нэгж
Нийт харилцагчийн тоо	849,074	885,610	949,775	Харилцагчдын тоо
Эмэгтэй	410,375	425,689	456,681	Харилцагчдын тоо
Эрэгтэй	438,699	383,259	411,140	Харилцагчдын тоо
Байгууллага	72,460	76,662	81,954	Харилцагчдын тоо
Нийт зээлдэгчийн тоо	100,617	102,504	102,439	Харилцагчдын тоо
Эмэгтэй	48,920	50,090	49,949	Харилцагчдын тоо
Эрэгтэй	50,400	51,245	50,524	Харилцагчдын тоо
Байгууллага	1,297	1,169	1,966	Харилцагчдын тоо
Нийт хадгаламж эзэмшигчийн тоо	342,548	352,809	346,087	Харилцагчдын тоо
Эмэгтэй	191,320	196,506	192,444	Харилцагчдын тоо
Эрэгтэй	150,894	155,808	153,199	Харилцагчдын тоо
Байгууллага	334	495	444	Харилцагчдын тоо
Нийт иргэн харилцагч	819,644	850,140	926,311	Харилцагчдын тоо
Эмэгтэй	410,335	425,652	456,644	Харилцагчдын тоо
Эрэгтэй	366,172	383,198	411,079	Харилцагчдын тоо
Байгууллага	43,137	41,290	58,588	Харилцагчдын тоо

Голомт банкны ажилтнуудын хүйсийн харьцаа

	2019	2020	2021	Хэмжих нэгж
Бодит ажилтны тоо	1971	1882	1916	
Эмэгтэй	1254	1198	1241	Ажилтны тоо
Эрэгтэй	717	684	675	Ажилтны тоо
Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан	10	15	21	Ажилтны тоо
Нэг буюу түүнээс дээш жил ажиллаж буй ажилтан	1637	1712	1620	Ажилтны тоо
Төвийн нэгж	868	839	875	
Эмэгтэй	503	487	520	Ажилтны тоо
Эрэгтэй	365	352	355	Ажилтны тоо
Салбар тооцооны төв	1103	1043	1041	
Эмэгтэй	751	711	721	Ажилтны тоо
Эрэгтэй	352	332	320	Ажилтны тоо
ТҮЗ-ийн гишүүд/ Газрын захирлууд	20	23	26	
Эмэгтэй	6	8	7	Ажилтны тоо
Эрэгтэй	14	15	19	Ажилтны тоо
Хэлтсийн захирлууд, Салбарын захирлууд	118	120	125	
Эмэгтэй	58	59	60	Ажилтны тоо
Эрэгтэй	60	61	65	Ажилтны тоо

Ажилтнуудад зориулсан сургалтын тоо

	2019	2020	2021	Хэмжих нэгж
Сургалтын нийт хүн/цаг	62849	117955	95185	Хүн/Цаг
Нэг ажилтанд ноогдох сургалтын цаг	31.9	66.3	50.1	Цаг
Нийт сургалтын тоо	317	637	753	Сургалтын тоо
Ногоон санхүүжилт	-	1105	1042	Хүн/Цаг
Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ	-	216	112	Хүн/цаг
Бодлого, журмын тухай сургалт	-	-	17.6	Хүн/цаг
Сертификаттай сургалт /ТОС/	-	724	190	Хүн/цаг

Ажилтнуудад зориулсан тэтгэмж, хөнгөлөлт

	2019	2020	2021	Хэмжих нэгж
Эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдсан	1333	-	1593	Ажилтны тоо
Хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж	578	550	937	Ажилтны тоо
Даавууны хоног авсан ажилтны тоо	95	78	65	Ажилтны тоо
Тэтгэвэр тогтоолгосон ажилтан	3	3	5	Ажилтны тоо
Ковид-19 вакцинд хамрагдсан ажилтны тоо /Нийт ажилтантай харьцуулахад	-	-	2009 / 97.6%	Ажилтны тоо
Ковид-19 вакцинд хамрагдсан ажилтны тоо /Нийт тунгийн давхардсан тоогоор/	-	-	5619	Ажилтны тоо

Бусад

	2019	2020	2021	Хэмжих нэгж
Ажилд авсан төгсөгчдийн тоо	150	142	206	Ажилтны тоо
Дадлагын оюутан	5	6	45	Ажилтны тоо
Ажилтнуудын эргэц	20.9%	15.6%	14.9%	Хувь
Engagement index	87%	80%	84%	Хувь
Төрсөн эхчүүдийн ажлын байрыг хадгалсан хувь	100%	100%	100%	Хувь

Байгаль орчныг хамгаалах болон нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн банкны дотоод үйл ажиллагаа

	2019	2020	2021	Хэмжих нэгж
Нийт эрчим хүчний хэрэглээ	1,101,753	1,406,035	1,429,886	Квт
Нийт дахивар хог хаягдлын хэмжээ	-	21.5кг + 30ш	21кг + 375ш	
Цаас	-	16	-	Килограмм
Хуванцар	-	3.4	3	Килограмм
Лааз	-	2.1	18	Килограмм
Шил	-	30	375	Ширхэг
Нийт усны хэрэглээ	8,004,000	6,892,000	4,897,000	Литр
Тэргэнцрийн налуу замтай салбарын тоо	30	32	40	Ширхэг
Бусад хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тоног төхөөрөмжийн тоо хэмжээ	103	131	141	Ширхэг
Тэргэнцэр	5	5	5	Ширхэг
Ойрын харааны нүдний шил	98	126	135	Ширхэг

ЦАХИЛГААН	2019	2020	2021
3-р оффис	205,586.60	199,716.50	161,405.70
2-р оффис	175,492.70	181,580.40	149,293.00
Төв оффис	578,100.00	822,767.50	881,321.65
Парк	142,574.00	201,971.00	237,866.00
Нийт	1,101,753.30	1,406,035.40	1,429,886.35

УС	2019	2020	2021
3-р оффис	2,030.00	1,624.00	1,026.00
2-р оффис	1,200.00	1,200.00	1,200.00
Төв оффис	3,033.00	1,886.00	1,092.00
Парк	1,741.00	2,182.00	1,579.00
Нийт	8,004.00	6,892.00	4,897.00

Харилцагчдын санал гомдлыг шийдвэрлэсэн байдал

	2019	2020	2021
Нийт гарсан гомдлын тоо	10,081	14,957	11,233
Шийдвэрлэсэн гомдлын хувь	100%	100%	100%
5 хоногийн дотор шийдвэрлэсэн гомдлын тоо	Системээс шүүгдэх боломжгүй.	2020 оны 8 сард СЕС систем ашиглалтад орсноос хойш ХДХМ нийт хүлээн авсан гомдлынхоо 77.6%-ийг 40 цаг буюу 5 хоногт багтаан шийдвэрлэсэн.	ХДХМ нийт хүлээн авсан гомдлын 79.1%-ийг 40 цаг буюу 5 хоногт багтаан шийдвэрлэсэн. Өмнөх жилээс 1.5%-иар өссөн эерэг үзүүлэлттэй байна.



www.golomtbank.com